

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Дорноговь аймгийн Сайншанд сумын 5 дугаар багийн 78 айлын орон сууцны барилгын дээврийн засварын ажил:**

А. Барилгын дээврийн засварын ажлыг дараах Барилгын норм ба дүрэм /БНБД/ стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх

Б. Ажил гүйцэтгэх хугацааны график /хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоо/-ийг тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.

В. Талбайн зохион байгуулалтын зураг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах төслийн баримт бичгийг тухайн ажилд нийцуулэн боловсруулах

Г. Үнийн саналд Барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 181 тоот тушаалын дагуу нэмэгдэл зардал, төлөвлөгөөт ашиг, техник хяналт, нормчолын сан, НӨАТ, магадлашгүй ажлын зардал зэргийг тооцож Барилгын төсөв зохиох дүрэм БНБД "IY" 81-95-12-г мөрдлөг болгоно.

Д. Авто тээврийн зардлыг ЗТЯ-ны 2013.07.10-ны өдрийн 162 тоот тушаалаар батлагдсан жишиг тарифаар тооцно.

Е. ЗТБХБС-ын 2012 оны 18 дугаар тушаалаар машин механизмын зардлыг тооцож ирүүлнэ.

Ж. Барилгын дээврийн засварын ажлыг дулааны улиралд хийж гүйцэтгэнэ.

### **Дээврийн ажил:**

- Дээврийн ажлыг гүйцэхдээ БНБД 31-02-03, БНБД 31-07-05, БНБД 31-08-05, бусад норм, стандартыг мөрдлөг болгоно.

- Дээврийн ажлыг дулааны улиралд чанарын маш өндөр түвшинд зураг төсөвт тусгасны дагуу хийж гүйцэтгэх шаардлагатай. Хуучин дээврийн хар цаасан хуйлмал материал, хуучин бетон тэгшилгээг хуулж сайтар цэвэрлэж тоос шороог нь даралттай усаар шуршиж цэвэрлэсний дараа зориулалтын 1 үе ус тусгаарлагч цавуут зуурмаг хийж дээврийн нийт гадаргууг хуурай толь бүхий материалыаар бүрнэ. Үүний дараа бетон зуурмагаар тэгшилгээ хийж дээврийг өнгөлнө.

- Дээврийн ажлыг гүйцэтгэхдээ хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг сайтар мөрдөж ажиллах шаардлагатай.

### **Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:**

1. Барилгын дээврийн засварын ажлыг зураг төсөв, ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
2. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсал мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
3. Барилгын дээврийн засварын ажлыг эхлүүлэхдээ иргэдийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулах зэрэг шаардлагатай арга хэмжээг авч гэнэтийн аюул осол гаргахгүй байхаар ажиллана.
4. Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүн, үнийн баримтыг хавсаргана.